БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2023/104/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Нурлан<br>Утас: 88403281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3
Асуудлыг онцолсон хэсэг ........ **Error! Bookmark not defined.**
Аудитын гол асуудал ........ **Error! Bookmark not defined.**
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ **Error! Bookmark not defined.**
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 15
4.1 Ерөнхий зүйл ........ 15
4.2 Материаллаг байдал ........ 15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 16
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 17
5.1 Төлбөрийн акт ........ 17
5.2 Албан шаардлага ........ 17
5.3 Зөвлөмж ........ 17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2023.02.20 № 102

танай ______ -ны № ______ -т

ЦАГААННУУР ТОСГОНЫ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ К.ГҮЛЖАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Улсын төсвийн хөрөнгө оруултаар 2020 онд ашиглтад орсон 240 хүүхдийн сургуулийн барилгын төсөвт өртөгт хамт тусгагдсан 99.4 сая төгрөгийн цэвэр, бохир усны 2 ширхэг авто машиныг хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **43,512,878.41** | **68,927,291.04** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 13,757,594.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 13,757,594.00 |
| **3121** | **Төгрөг** | - | 13,757,594.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 13,757,594.00 |
| **33** | **АВЛАГА** | 96,349.00 | 182,730.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 96,349.00 | 182,730.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | - | 9,720,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 9,720,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 43,416,529.41 | 45,266,967.04 |
| **351** | **Түүхий эд материал** | 12,481,618.89 | 12,481,618.89 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 12,481,618.89 | 12,481,618.89 |
| **354** | **Хангамжийн материал** | 30,934,910.52 | 32,785,348.15 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,174,561.07 | 2,431,131.07 |
| 35420 | Аж ахуйн материал | 21,896,803.00 | 23,500,623.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 424,150.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,033,086.45 | 1,338,984.08 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,830,460.00 | 5,090,460.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,586,154,134.78** | **2,610,601,487.83** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,586,154,134.78 | 2,610,601,487.83 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,547,033,734.78 | 2,571,291,487.83 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,566,272,328.00 | 2,566,272,328.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (116,301,514.51) | (167,197,378.39) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | - | 99,431,250.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - | (7,457,343.75) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 83,246,965.90 | 85,216,965.90 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (57,595,979.81) | (66,944,340.17) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 71,609,459.48 | 71,609,459.48 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (33,847,399.41) | (43,485,391.41) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (333,333.32) | (1,333,333.28) |
| 39217 | Ном | 23,983,208.45 | 25,179,271.45 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 39,120,400.00 | 39,310,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 39,120,400.00 | 39,310,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,629,667,013.19** | **2,679,528,778.87** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **626,990.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 626,990.00 |
| **413** | **Өглөг** | - | 626,990.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 626,990.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,629,667,013.19** | **2,678,901,788.87** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,629,667,013.19 | 2,678,901,788.87 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 272,770,780.68 | 272,770,780.68 |
| 51101 | Өмч: - төрийн | 272,770,780.68 | 272,770,780.68 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,859,012,504.51 | 1,908,247,280.19 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,848,455,704.65 | 1,859,012,504.51 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 10,556,799.86 | 49,234,775.68 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 497,883,728.00 | 497,883,728.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,629,667,013.19** | **2,679,528,778.87** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **749,238,128.79** | **902,331,013.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **11,299,156.08** | **1,385,663.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 11,299,156.08 | 1,385,663.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 11,299,156.08 | 1,385,663.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 11,299,156.08 | 1,385,663.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **737,938,972.71** | **900,945,350.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 658,267,145.71 | 781,613,850.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 682,182,600.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 58,457,645.71 | 99,431,250.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 599,809,500.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 467,427.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 467,427.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 79,204,400.00 | 119,331,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 79,204,400.00 | 119,331,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **738,681,328.93** | **853,096,237.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **738,681,328.93** | **853,096,237.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 717,313,751.93 | 820,386,187.32 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 488,685,500.00 | 568,920,346.00 |
| 210101 | Үндсэн цалин | 425,387,800.00 | 451,568,457.00 |
| 210102 | Нэмэгдэл | - | 100,897,734.00 |
| 210104 | Урамшуулал | 31,533,200.00 | 16,454,155.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 31,764,500.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 66,171,600.00 | 71,268,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,565,300.00 | 48,462,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,901,500.00 | 5,701,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,921,300.00 | 4,561,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 980,300.00 | 1,140,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,803,200.00 | 11,402,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 75,431,095.00 | 67,033,735.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,404,209.00 | 4,014,630.00 |
| 210302 | Түлш, халаалт | 71,791,415.00 | 61,051,140.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,235,471.00 | 1,967,965.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,188,416.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 1,393,900.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,048,727.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 493,800.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 110,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,141,989.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 12,372,833.75 | 17,991,321.37 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 250,500.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 10,478,823.75 | 17,991,321.37 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,643,510.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 526,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 526,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 196,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 196,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 570,000.00 | 1,958,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 70,000.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,958,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 67,698,307.18 | 92,687,584.95 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 10,257,345.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,608,250.00 | 4,090,680.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 66,090,057.18 | 78,339,559.95 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 21,367,577.00 | 32,710,050.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,249,500.00 | 32,710,050.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 19,249,500.00 | 32,710,050.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,118,077.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,118,077.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **10,556,799.86** | **49,234,775.68** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **10,556,799.86** | **49,234,775.68** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **679,481,327.00** | **801,514,100.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **679,481,327.00** | **801,514,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 599,809,500.00 | 682,182,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 599,809,500.00 | 682,182,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 467,427.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 467,427.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 79,204,400.00 | 119,331,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 79,204,400.00 | 119,331,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **677,971,327.00** | **776,066,506.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **677,971,327.00** | **776,066,506.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **656,603,750.00** | **743,356,456.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 488,261,323.00 | 569,006,727.00 |
| 210101 | Үндсэн цалин | 424,963,623.00 | 451,654,838.00 |
| 210102 | Нэмэгдэл | | 100,897,734.00 |
| 210104 | Урамшуулал | 31,533,200.00 | 16,454,155.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 31,764,500.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 66,171,600.00 | 71,268,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,565,300.00 | 48,462,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,901,500.00 | 5,701,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,921,300.00 | 4,561,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 980,300.00 | 1,140,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,803,200.00 | 11,402,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 79,204,400.00 | 66,830,895.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,054,000.00 | 2,877,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 75,900,450.00 | 61,453,895.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,249,950.00 | 2,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,137,727.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 172,000.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,048,727.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 902,800.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | 245,600.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 768,600.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 14,884,600.00 | 16,999,689.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 111,300.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 14,037,200.00 | 16,999,689.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 736,100.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 196,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 196,000.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 745,600.00 | 2,394,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 245,600.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 2,394,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,002,500.00 | 16,256,545.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 11,467,645.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,002,500.00 | 4,788,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **21,367,577.00** | **32,710,050.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,249,500.00 | 32,710,050.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 19,249,500.00 | 32,710,050.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,118,077.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,118,077.00 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,510,000.00** | **25,447,594.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,510,000.00** | **11,690,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,510,000.00** | **11,690,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,510,000.00 | 11,690,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,510,000.00 | 11,690,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(1,510,000.00)** | **(11,690,000.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 13,757,594.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 13,757,594.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 233,650,380.68 | 335,604,096.00 | -56,909,337.67 | 512,345,139.01 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 1,894,418.00 | 1,894,418.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **233,650,380.68** | **335,604,096.00** | **-55,014,919.67** | 514,239,557.01 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | -1,894,418.00 | | -1,894,418.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | -30,694,876.48 | -30,694,876.48 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **272,770,780.68** | **497,883,728.00** | **1,859,012,504.51** | 2,629,667,013.19 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **272,770,780.68** | **497,883,728.00** | **1,859,012,504.51** | 2,629,667,013.19 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **272,770,780.68** | **497,883,728.00** | **1,859,012,504.51** | 2,629,667,013.19 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 49,234,775.68 | 49,234,775.68 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **272,770,780.68** | **497,883,728.00** | **1,908,247,280.19** | 2,678,901,788.87 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **801,514,100.00** | **787,756,506.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **801,514,100.00** | **787,756,506.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **768,249,800.00** | **755,046,456.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **571,330,900.00** | **569,006,727.00** |
| 210101 | Үндсэн цалин | 453,978,800.00 | 451,654,838.00 |
| 210102 | Нэмэгдэл | 100,897,900.00 | 100,897,734.00 |
| 210104 | Урамшуулал | 16,454,200.00 | 16,454,155.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **71,268,600.00** | **71,268,600.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,462,700.00 | 48,462,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,701,600.00 | 5,701,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,561,100.00 | 4,561,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,140,300.00 | 1,140,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,402,900.00 | 11,402,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **68,616,600.00** | **66,830,895.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,877,000.00 | 2,877,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 63,239,600.00 | 61,453,895.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **21,834,100.00** | **16,999,689.00** |
| 210502 | Хоол, хүнс | 21,834,100.00 | 16,999,689.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 600,000.00 | 600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 600,000.00 | 600,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,332,600.00** | **2,654,000.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,332,600.00 | 2,654,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30,267,000.00 | 27,686,545.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,768,100.00 | 21,187,645.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,498,900.00 | 6,498,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 33,264,300.00 | 32,710,050.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 33,264,300.00 | 32,710,050.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 33,264,300.00 | 32,710,050.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **801,514,100.00** | **801,514,100.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **682,182,600.00** | **682,182,600.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 682,182,600.00 | 682,182,600.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **119,331,500.00** | **119,331,500.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 119,331,500.00 | 119,331,500.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 13,757,594.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **50** | **51** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 22 | 22 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 27 | 28 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 1 | 1 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 1 | 1 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1 | 1 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар**

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь сурагчдад анхан болон суурь мэдлэг олгох, сурлагын чанарыг дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан 4 зорилгын хүрээнд 28 арга хэмжээг дэвшүүлж ажилласан байна.Үүнд:

- Боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах хяналт  тавих
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
- Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт
- Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4 зорилгын  28 арга хэмжээг аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас 87.2 хувиар үнэлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар**

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах  шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь сургуулийн захирлын 2020 оны 05 сарын 01-ны өдрийн А/09 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49.8 сая төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 13,757.6 | 13,757.6 |
| Авлага | 96.3 | 182.7 | 86.4 |
| Урьдчилж гарсан зардал | 0 | 9,720.0 | 9,720.0 |
| Бараа материал | 43,416.5 | 45,266.9 | 1,850.4 |
| Үндсэн хөрөнгө | 2,586,145.1 | 2,610,601.5 | 2,566.3 |
| **Нийт хөрөнгө** | **2,629,667.0** | **2,679,528.8** | **49,861.8** |
| Өр төлбөр | | | 626,9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,629,667.0 | 2,679,528,8 | 49,861.8 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,629,667.0** | **2,679,528.8** | **49,861.8** |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө 13.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь зарцуулагдаагүй санхүүжилтийн үлдэгдэл байна. Урьдчилж гарсан зардал 9.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Саммит компьютер технологи ХХК-тай байгуулсан БӨАЦНТЕБС/003/001 тоот гэрээний дагуу 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдөр мөнгө шилжүүлсэн боловч тус компани нь хөрөнгө нийлүүлээгүйтэй холбоотой байна.

Бараа материалын данс 1.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бичиг хэрэг, аж ахуйн материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 2.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд хандиваар 1.2 сая төгрөгийн, хөрөнгийн санхүүжилтээр 99.4 сая төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 1.9 сая төгрөгийн

хөрөнгө худалдан авч үндсэн хөрөнгөд 78.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 49.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсөв болон орон нутгийн төсвөөс 788.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 788.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас улсын төсвийн цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 5.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 71.3 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 4.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 19.2 сая төгрөгөөр нэмэгдэж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 7.9 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 12.2 сая төгрөгөө бууруулж, орон нутгийн төсвийн төсвийг 39.8 сая төгрөгөөр нийт 12.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 801.5 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 12.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 801.5 сая төгрөгийг улсын төсөв болон орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 119.3 сая төгрөгийг, улсын төсвөөс 682.2 сая төгрөгийг нийтдээ 801.5 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 787.7 сая төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 13.7 сая төгрөгөөр дутуу зарцуулж жилийн эцэст 13.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | **Улсын төсвийн** | | | | |
| 1.1 | Байр ашиглалтын үйлчилгээ | 1,733.0 | 1,733.0 | 0 | 100 |
| 1.2 | Сургалт семинар | 866.5 | 866.5 | 0 | 100 |
| 1.3 | Үдийн цай хөтөлбөр | 33,264.3 | 32,710.0 | 554.2 | 98.3 |
| 1.4 | Дотуур байрны үйлчилгээ | 22,954.1 | 18,110.2 | 4,843.9 | 78.9 |
| 1.5 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,990.0 | 9,720.0 | 2,270.0 | 81.1 |
| 1.6 | Боловсролын байгууллагын багш | 3,899.3 | 3,574.0 | 325.3 | 91.6 |
| 1.7 | Боловсролын стандарт, сургалтын | 477,439.3 | 473,461.0 | 3,978.3 | 99.2 |
| 1.8 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 128,043.1 | 128,043.1 | 0 | 100 |
| 1.9 | Эрүүл мэндийг дэмжих | 1,993.0 | 1,993.0 | 0 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | **Орон нутгийн төсвийн** | | | | |
| 2.1 | Нийтлэг үйлчилгээ | 119,331.5 | 117,175.8 | 1,785.9 | 98.2 |
| | **Дүн** | **801,514.10**<br>**801,514.1** | **787,386.60**<br>**787,756.5** | **13,757.6**<br>**-13,757.6** | **98.2**<br>**98.2%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 738.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 11.8 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшил 2.3 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1.8 сая төгрөгөөр, нормативт зардал 4.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1.7 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 2.6 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг 0.5 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 25%, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 75% байна. Тайлант онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 60.0 сая төгрөг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 29.1 сая төгрөгийн 23 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Аудитын дүнгээр шилэн дансны зөрлийг арилгуулах албан шаардлага өгөгдлөө.
Тус сургуулийн 2022 оны шилэн дансны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

**4.4.2** Бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааг явуулсан байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, албан шаардлага өгөгдөөгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 9.7 сая төгрөгийн залруулаг хийгдсэн.

Аудитаар “Саммит компьютер технологи” ХХК-д компьютер худалдан авахаар 9.7 сая төгрөгийг шилжүүлж, хөрөнгөө хүлээж аваагүй авлагаар бүртгэж тайлагнасныг урьдчилж гарсан зардлаар бүргүүлж залруулав.

*Хууль хяналтын байгууллагад албан шаардлагаар шилжүүлсэн, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн асуудал байхгүй.*

Аудитаар нийт 141.0 сая төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 1.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 87.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 51.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Сургуулийн захирал нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 дугаар 01-ны өдрийн А/35, А/10/9 дүгээр хамтарсан тушаалыг баримтлалгүйгээр аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/182 тоот захирамжаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн садын 2010 оны хүчингүй болсон 362/112/183 дугаар хамтарсан тушаалыг үндэслэж 1.7 сая төгрөгийн ур чадварыг нэмэгдлийг авч төсвөөс илүү зарлага гаргасныг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1.Сургуулийн захирлын 2022 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн Б/11 тоот тушаалаар үдийн хоолны тогоочийг шинээр ажилд авч төсвөөс 5,249.4 мянган төгрөгийн зардал гаргаж, захирлын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Ажил албан тушаалын жагсаалт батлах тухай” А/01 тоот тушаалаар тогтоосон орон тоог 1 хүнээр хэтрүүлэн ажиллуулсан. Хоолны зардлын батлагдсан төсвөөс 750.0 мянган төгрөгөөр тайзны хөшиг худалдан авч нормативт зардлыг зориулалтын бус зарцуулсан зөрчлүүдэд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

2. “Саммит компьютер технологи” ХХК-нд 9.7 сая төгрөгийг шилжүүлж авлагаар бүртгэсэн зөрчилд гэрээний хэрэгжилтийг хангуулахаар албан шаардлага өгөв.

3.Шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 21.9 сая төгрөгийн 23 шийдвэр, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 60.0 сая төгрөгийн 7 удаагийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдал 25 хувьтай байгаа зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

---

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*1.1.Илрүүлэлт:* Тайлант онд үдийн хоол, албан томилолт, түлш халаалт, тээвэр шатахуун, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, гэр интернэтийн, засварын материал, хүнсний үнэ, шуудан холбоо, интернэтийн үнэ, сургалтын төлбөрийн зардлаас нийт 51.4 сая төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

1.*2. Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2, 20.2, 20.2.6 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж аливаа гүйлгээг тооцооны данс дамжуулан бүртгэж тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| “Саммит компьютер технологи” ХХК-нд 9.7 сая төгрөгийг шилжүүлж авлагаар бүртгэж тайлагнасан. | 1 | 9,720.0 | | | 1 | 9,720.0 | 1 | 9,720.0 | | | | |
| **Дүн** | **1** | **9,720.0** | | | 1 | 9,720.0 | **1** | **9,720.0** | | | | |

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн | 4 | 59,161.9 | 1 | 1,720.1 | | | | | | | | |
| Батлагдсан орон тооноос 1 тогоочийг шинээр ажилд авсан, Хоолны зардлаас тайзны хөшиг худалдан авсан | | | | | 1 | 5 999.4 | | | | | | |
| “Саммит компьютер технологи” ХХК-нд 9.7 сая төгрөгийг шилжүүлж авлагаар бүртгэсэн | | | | | 1 | | | | | | | |
| Нийт 51.4 сая төгрөгийн гүйлгээг шууд зардлаар бүртгэж тайлагнасан | | | | | | | 1 | 51,442.4 | | | | |
| **Дүн** | **4** | **59.161.9** | **1** | **1,720.1** | **2** | **5,999.4** | **1** | **51,442.4** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 23 шийдвэр, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 7 удаагийн мөнгөн гүйлгээг тус тус мэдээлээгүй | 1 | 81,934.9 | | | 1 | 81,934.9 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дүн | **1** | **81,934.9** | | | **1** | **81,934.9** | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **81,934.9** | | | **1** | **81,934.9** | | |